

**ХОВД ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ШИЙДВЭР, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

/2016 ОНЫ 12 САРЫН 20-НЫ ӨДРИЙН ХУРАЛ/

- Төгсөлтийн шалгалттай холбоотой асуудлуудыг холбогдох өөрчлөлтийг оруулан тус тус батлан тушаал гаргахаар шийдвэрлэв. Төгсөлтийн шалгалтын комисс, Төгсөлтийн шалгалтын хуваарь, Төгсөлтийн шалгалтад орох оюутны нэрсийг гаргахыг Д.Өрнөхдэлгэр Бүрэлдэхүүний сургуулийн захирлуудад даалгав.
- Зарим багш нарын цалинтай, цалингүй чөлөө, унааны зардал, хүссэн өргөдлийг дараах байдлаар шийдвэрлэв.
- Д.Одончимэг /НААЗ-н тэнхимийн багш/ Урьд эрхэлж байсан ажилд 12 сарын 16-наас эргэж орохоор болов.
- 2017-2018 оны хичээлийн жилд Оюутны универсиад наадмыг ХИС зохион байгуулахтай холбоотой дараах үүргийг өгөв. Үүнд: Эртнээс удирдамж боловсруулж ажлын хэсэг томилох, Хамрах хүрээг өргөжүүлэх гэж байгаа сайн талтай үүнийгээ бодитой болгох, Спорт урлагийн төрлөө баяжуулах хэрэгтэй, Наадмын удирдамжийг сайн боловсруулж 2 хэлдээр хөрвүүлэх, Зардлын асуудлыг тодорхой нарийн гаргах/виз, зардал г м/, БСШУСЯ руу хандсан бичиг явуулж дэмжсэн захиа авах, Хөрөнгө босгох асуудлаа эртнээс зохицуулахыг Б.Цэрэндаваад үүрэг болгов
- Швейцарь номын санг шилжүүлэн ажилласан ажлын хэсгийн тайланг сонсов. Энэ үйл ажиллагаатай холбоотой 12 сарын 17, 18-ны амралтын 2 өдөр ажилласан 8 хүнийг оюутны амралтын үеэр нөхөн амруулахаар шийдвэрлэв
- ХИС-ийн оюутны шинэ жилийн үйл ажиллагааг 12 сарын 27-ны өдөр тэмдэглэхээр болов. Үүнтэй холбоотой: Бэлэг өгөх хүмүүсийн нэрсийг нягтлах, Шинэ жилийн үйл ажиллагааны төсвийг сайн хянаж тушаал гаргах, Лицей сургуулийн шинэ жилийн үйл ажиллагааг 12 сарын 26-ны өдөр тэмдэглэхээр шийдвэрлэв.
- Ажлын байранд зохисгүй үйлдэл гаргасан багш, ажилтанд сахилгын шийтгэл ногдуулахыг Ц.Буянбатад даалгав.
- Баян-Өлгий аймгийн салбар сургуулийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухай С.Гаура танилцуулав.
- Баян-Өлгий аймгийн салбар сургуулийн бүтэц өөрчлөх, орон тоо нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэв.
- ХИС-ийн “Удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд багшийн төлөөлөл сонгохоор хамт олны хурлыг 12 сарын 26-ны өдрийн 13⁰⁰ цагаас хийхээр шийдвэрлэв.
- ХИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлыг 12 сарын 27-ны өдрийн 10⁰⁰ цагаас хийхээр шийдвэрлэж, Захиргааны зөвлөлийн зүгээс ЭЗ-ийн дүрмийг шинэчлэх тухай, Шинэ мэргэжлийн хөтөлбөр, төлөвлөгөө танилцуулах тухай, Хүрээлэнгийн дүрэм батлуулах тухай, Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлуулах тухай, ХИС-ийн суралцагчдад хөнгөлөлт үзүүлэх журмын төслийг хэлэлцүүлэх тухайдараах асуудлуудыг оруулахаар шийдвэрлэв.
- Гадаад болон дотоодод томилолтоор ажилласан багш нарын тайлан тавих график гаргахаар тогтов.
- ХИС-ийн сургалтын хөтөлбөрүүдэд чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, хөндлөнгийн дүгнэлт гаргах удирдамж боловсруулж, ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэв.
- Сургалтын алба болон Санхүүгийн албаны “Санхүүгийн үйл ажиллагааны календарь” болон “Сургалтын үйл ажиллагааны календарь” гаргахаар тогтов.
- 2016 оны 12 сарын 22-ны өдөр 16:00 цагаас PhD –д сурч байгаа ХИС-ийн багш, ажилчидтай уулзаж Гадаадын их, дээд сургуулиудад тэтгэлгээр суралцуулах PhD-ийн хөтөлбөрүүдийн танилцуулга хийх, бэлтгэл ажлыг зохион байгуулах, сургалтын төлөвлөгөө боловсруулах тухай танилцуулахаар шийдвэрлэв.
- Диплом хүчингүй болгох тухай асуудлыг ажлын хэсэг гарган нягтлуулахаар шийдвэрлэв.

Захиргааны зөвлөлийн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын чиглэлийг гаргасан:

**Б.Болормаа /Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн/
Ц.Буянбат /Хуулийн зөвлөх/**